

ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын
өрөнхий хуулийн шинэчилсэн
наиргуулгын төсөл*

Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тус тус дэвшигүүлсэн нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулан, 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн билээ.

Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсний дараа УИХ-аас Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, Засгийн газраас 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 15-43 хувиар нэмэгдүүлсэн нь өргөн мэдүүлсэн багц хуулийн төсөлд тусгасан зарим зүйл, заалтыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн.

Мөн УИХ дахь олонхиin бүлгээс хуулийн төслүүдийг хуримтлалын нэгдсэн сантай уялдуулж дахин боловсруулах чиглэл өгсөн, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон зэрэг шалтгааны улмаас Нийгмийн даатгалын өрөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг буцаан татан авч, үүсэх нөхцөл байдалд нийцүүлэн дахин боловсруулав.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлэх, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдаж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бие даасан тогтолцоог бий болгох, нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтууд тусгагдсан.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх, даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдүүлэх, хуримтлалын нэгдсэн сан байгуулж иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийхээр тусгасан нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Нийгмийн даатгалын тухай хууль нь 1994 онд батлагдсан бөгөөд үүнээс хойш орсон 31 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн хувь

хэмжээг өөрчлөх, нийгмийн даатгалын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг тэтгэвэр авагч, даатгуулагчийн эрх ашигт нийцсэн олон арга хэмжээг хуульчлан хэрэгжүүлсэн.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын ажиллах хүчний 82.2 орчим хувь нь нийгмийн даатгалд даатгуулж, жилд дунджаар давхардсан тоогоор 748.9 мянга орчим хүнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, нөхөн төлбөр олгож байна. Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олготг, даатгуулагчийн шимтгэл төлөх хувь хэмжээ, орлогын бүрэлдэхүүн, албан журмын даатгалын хамрах хүрээ, төрөл, нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо, байгууллага, байцаагчийн үйл ажиллагаа зэрэг харилцааг зохицуулж байна.

Хамралтын хувь хэмжээ баагүй байгаа хэдий ч малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх хувь нь нийгмийн даатгалд хамрагдахгүй нийгмийн баталгаа нь алдагдаж байгаа тул нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх шаардлагатай байна.

Түүнчлэн зарим салбарын хууль тогтоомжоор нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр тогтоох харилцааг зохицуулсан нь хуулийн хийдэл үүсэж байна. Тухайлбал, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Дипломат албаны тухай хуульд хуулиар шимтгэл төлсөн хугацаа, өндөр насны тэтгэвэрт гарах нас, тэтгэвэр бодох хувь хэмжээг зохицуулсан нь нийгмийн даатгалын харилцааг нарийвчлан зохицуулсан хуулиудтай зөрчилдөж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд нийгмийн даатгалын чиглэлээр авч хэрэгжүүлж буй зарим бодлого, үйл ажиллагаа болон ирээдүйд ирэх хүн амын наскилтаас хамаарч нийгмийн даатгалын сангийн зардал улам өсөж, тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нэмэгдэхээр байгаа тул нийгмийн даатгалын сангуудын санхүүгийн тогтвортой, бие даасан байдлыг хангасан сангийн зөв менежментийг хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийхээр заасан тул тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжих, даатгалын сангийн ирээдүйн алдагдлыг бууруулах, нэрийн дансны бүртгэлийг мөнгөжүүлэх зорилгоор өнөөдрөөс тэтгэврийн даатгалын сангийн бодит хуримтлалыг эхлүүлэх шаардлагатай байгаа юм.

Нийгмийн даатгалтай холбогдсон харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулах, нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдлыг бүрдүүлэх, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эрсдэлгүй, үр өгөөжтэй удирдах, даатгалын сангийн бодит хуримтлалыг эхлүүлэх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох харилцааг тусгана. Мөн нийгмийн даатгалын тогтолцооны зарчим, даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын итгэлцүүр, шимтгэлийг нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн нөөц санг байгуулах, нэрийн дансны бүртгэлийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх, шимтгэлийн өр, хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, нийгмийн даатгалын сангийн хэтийн тооцоолол хийх, сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороог ажиллуулах зэрэг шинэ зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн нийгмийн даатгалын байгууллага, даатгалын ажилтнуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, үйл ажиллагаа нь ил тод, нийгмийн даатгалын тогтолцоонд итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг дээшлүүлэх зарчмыг хуулийн төсөлд тусгасан болно.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй уялдуулан 51 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар гарна. Үүнд:

- нийгмийн даатгалын хамрах хүрээ өргөжнө;
- нийгмийн даатгалын сангийн санхүүгийн чадавх сайжирч, тогтвортой байх нөхцөл бүрдэнэ;
- нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнийг хуульчилснаар хуулийг хэрэгжүүлэхэд хялбар, ойлгомжтой болно;
- нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд оруулах боломж бүрдэж, түүнд тавих хяналт сайжирна;
- даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийн бодит хуримтлалтай болох эрх зүйн үндэс тавигдана;
- нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, тооцоо, хэтийн тооцоолол хийх, эрсдэлийг үнэлэх мэргэжлийн хороо ажиллана;
- нийгмийн даатгалын засаглал оновчтой болж, ажлын уялдаа холбоо сайжирч, нийгмийн даатгалын байгууллага, ажилтны эрх, чиг үүрэг тодорхой болж, ажилтны чадавх сайжирна;
- нийгмийн даатгалын үйлчилгээ цахимжиж ажил олгогч, даатгуулагч нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай, ил тод, нээлттэй авах нөхцөл бүрдэнэ;
- ажил олгогч, даатгуулагчийн чиг үүрэг ойлгомжтой, тодорхой болно гэж үзэж байна.

Хуулийг 2024 оноос хэрэгжинэ гэвэл даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг мөнгөжүүлэх зориулалтаар тэтгэврийн даатгалын санд олгох улсын төсвийн татаас 291.6 тэрбум төгрөг, зарим иргэдийн шимтгэлийг улсын төсвөөс хариуцах 48.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэх тооцоолол байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР